



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/140

Бат-Өлзий сум

┌ Сонгуулийн санал авах өдрүүдэд
авах арга хэмжээний тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын “Сонгуулийн санал авах өдрүүдэд авах арга хэмжээний тухай” 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/505 дугаар захирамжийг тус тус үндэслэн захирамжлах нь.

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдрүүд буюу 2024 оны 06 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хориглосугай.

2. Мөн 2024 оны 06 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд соёл урлаг, үзвэр, спорт бусад нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байх, 6 дугаар сарын 28-ны өдөр гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдийг хааж, үйл ажиллагааг түр хориглох арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, хошууч (Д.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

3. Дээрх чиглэлийг төрийн байгууллагууд, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдэгдэл хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, хошууч (Д.Энх-Амгалан), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Э.Бадамханд) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

022301197